

Нэгдүгээр хэсэг. СОНГОХ ДААЛГАВАР

Санамж: Хариултын хуудасны заавартай сайтар танилцана уу.

- Энэхүү хэсэг нь 40 сонгох даалгавар, нийт 80 оноотой.
- Монгол хэл, уран зохиол, үндэсний бичгийн нэгдмэл агуулгаас бүрдэнэ.
- Даалгавар бүр 5 сонгох хариулттай бөгөөд зөвхөн нэгийг сонгоорой.
- Сонгосон хариултаа хариултын хуудсанд будаж тэмдэглээрэй.

Монгол хэл:

- Эсээг анхааралтай уншиж ойлгоод, даалгаврыг гүйцэтгээрэй.

Нүүдэлчдийн сэтгэлгээ (эсээ)

4

Хүн төрөлхтний үлэг оршил нь нүүдэл. Нүүдэл гэдэг нь хөдөлгөөн. Оршин байхын үндэс нь хөдөлгөөн. Чухамхүү үргэлжийн хөдөлгөөн л амгаланг буй болгоно. Амгалангаас илүү жаргалан гэж үгүй.

...Тайван тогтонги, зуршил хэвшлийг эрхэмлэдэг үндэстэн бол монголчууд. Эргэх дөрвөн цагийн турш хөдөлгөөнд оршиж байдаг атлаа хувьсал өөрчлөлтгүй байхыг ямагт эрмэлздэгийн учир бол хөдөлгөөн гэгч өөрөө тайван тогтонгийг үүддэгт оршино. Тийм учраас амьдралынх нь хэм хэмнэл, амь зуулгынх нь арга, өдөр тутмынх нь ажил үйлс нэгэн хэвийн, нэгэн голдиролт бөгөөд чухамхүү энэ хөдөлгөөн хийгээд тогтонги нь бусдаас ялгагдах аж төрөх ёсыг бий болгожээ.

Хүрээлэн буй орчных нь уул ус, гүвээ толгод, адуу малын бэлчээр хорь гуч хоногийн давтамжтайгаар өөрчлөн шинэчлэгдэж байдаг ч үүд хоймрын нь орших зүг, гэр доторх эд агуурсынх нь байрлал, тэр ч бүү хэл хониных нь хот, үхэр тугал, ингэ ботгоных нь зэл ямар ч улиралд хэд хэчнээн ч нүүж, хаа ч буулаа гэсэн анх айл болоод байрлуулсан байр, зүг чигийг нь хэзээ ч өөрчилдөггүй. Гэр дотроо нүүдэггүйтэйгээ нэг адил гэрийн гадаах орчноо ч өөрчилдөггүй. Өөрөөр хэлбэл хэд ч нүүж, хаа ч буусан гэр доторх хийгээд гэрийн гадаах өөрсдийн буй болгосон орчныг тэр чигээр нь ямар ч өөрчлөлтгүйгээр аваад яваад байдаг гэсэн үг юм. Эцэг өвгөдөөс уламжилж ирсэн эд юмсын байрлал, зүг чигийг хэдэн үеэрээ өөрчлөөгүй айл бишгүй байдаг. Хэвшил зуршил бий болгох үйл явц гэр орон, эд агуурсын байрлал зүг чигээр хязгаарлагддаггүй, мал маллагаандаа хүртэл нэвтрүүлсэн байдаг.

Ямар ч малыг маллагаа, уналга эдэлгээнд сургахдаа тогтмол харилцаа, дадал зуршилтай болгохыг зорьдог. Энэ зорилгынхоо үүднээс мал маллагааныхаа зарим хэрэгслийг өөрчилсөн нь ажиглагддаг.

Дэлхий даяараа бугуйл хэрэглэж мал адгуусыг барьдаг. Одоо ч тийм. Гэтэл төв халхууд бугуйлыг уургаар солиод бараг таван зуун оныг үдсэн аж. Малыг сургах л гэж тэр. Уургад сайн хэвшсэн морь уургын үзүүр толгойнх нь тус газарт очиход л өөрөө зогсон баригддаг. Ерөөс малыг сургахдаа монголчууд гаргууд. Хэвшүүлсэн зуршлыг нь гажуудуулах үед “Мал муу зан сургалаа” хэмээн зэмлэдэг.

Нүүдэлчин монголчуудын амьдралын дэг журам, хэвшил зуршил, дадал заншил бол нүүдэл дунд бий болгосон суурьшил. Энэхүү өвөрмөц нүүдэлт-суурьшлын талаар дэлхийн түүхэнд зураг сэлттэйгээ үлдсэн баримт бол XIII зууны үеийн монгол хаадын олон арван шар хөллөн нүүдэг их гэр тэрэг нь юм. Ийм их гэр тэрэгнээс гадна дөрөв, найман үхэр хөллөсөн бэсрэг гэр тэрэгнүүд ч олон байсан байж таарна. Тэр цагийн хаадын нүүж яваа хүрээ, суурин иргэдийн жуулчин, хэсүүлчний нүдэнд талын энгээр алгуурхан хөдөлж байгаа хот мэтээр төсөөлөгддөг байсан нь дээрх дүгнэлтийг батлах наад захын баталгаа юм.

Дарма.Батбаяр

1. Эсээнд буй үг ямар утга илэрхийлж байна вэ? Тайлбартай нь харгалзуулаад тохирох хувилбарыг сонгоорой.

Үг	Харгалзаа	Үгийн тайлбар
1. зуулга	○	○ а. багахан, жижиг
2. зэл	○	○ б. мал гөрөөсний хэвтэшлэх газар
3. бэсрэг	○	○ с. эзлэх талбай, хэмжээ
4. эн	○	○ д. газарт сунган татсан мал уях хэрэгсэл
5. хот	○	○ е. хоол тэжээл, хүнс

- A. 1e, 2d, 3b, 4c, 5a
 B. 1d, 2e, 3c, 4a, 5b
 C. 1e, 2d, 3a, 4c, 5b
 D. 1d, 2b, 3a, 4e, 5c
 E. 1e, 2c, 3b, 4d, 5a



2. Эсээний хөтөч санаа аль нь вэ?
- Амьдралынх нь хэм хэмнэл, амь зуулгынх нь арга, өдөр тутмынх нь ажил үйлс нэгэн хэвийн, нэгэн голдиролт бөгөөд чухамхүү энэ хөдөлгөөн хийгээд тогтонги нь бусдаас ялгагдах аж төрөх ёсыг бий болгожээ.
 - Хүрээлэн буй орчных нь уул ус, гүвээ толгод, адуу малын бэлчээр хорь гуч хоногийн давтамжтайгаар өөрчлөн шинэчлэгдэж байдаг.
 - Оршин байхын үндэс нь хөдөлгөөн. Чухамхүү үргэлжийн хөдөлгөөн л амгаланг буй болгоно. Амгалангаас илүү жаргалан гэж үгүй.
 - Хүн төрөлхтний үлэг оршил нь нүүдэл. Нүүдэл гэдэг нь хөдөлгөөн. Оршин байхын үндэс нь хөдөлгөөн.
 - Амгалангаас илүү жаргалан гэж үгүй. ...Тайван тогтонги, зуршил хэвшлийг эрхэмлэдэг үндэстэн бол монголчууд.
3. “Хэвшил зуршил бий болгох үйл явц гэр орон, эд агуурсын байрлал зүг чигээр хязгаарлагддаггүй, мал маллагаандаа хүртэл нэвтрүүлсэн байдаг.” гэсэн толгой өгүүлбэрийн дэмжих өгүүлбэр аль нь вэ?
- Нүүдэлчин монголчуудын амьдралын дэг журам, хэвшил зуршил, дадал заншил бол нүүдэл дунд бий болгосон суурьшил.
 - Уургад сайн хэвшсэн морь уургын үзүүр толгойнх нь тус газарт очиход л өөрөө зогсон баригддаг.
 - Эцэг өвгөдөөс уламжилж ирсэн эд юмсын байрлал, зүг чигийг хэдэн үеэрээ өөрчлөөгүй айл бишгүй байдаг.
 - Их гэр тэрэгнээс гадна дөрөв, найман үхэр хөллөсөн бэсрэг гэр тэрэгнүүд ч олон байсан байж таарна.
 - Тайван тогтонги, зуршил хэвшлийг эрхэмлэдэг үндэстэн бол монголчууд.
4. Эсээний дэвшүүлсэн асуудлыг зөв тодорхойлсныг олно уу.
- Монголчууд гэр тэрэг хөллөн нүүдэллэдэг байсан тухай
 - Эцэг өвгөдийн уламжлалыг сахиж дээдлэх тухай
 - Монголчууд нүүдэллэх үедээ тогтвортой амьдардаг тухай
 - Монголчуудын нүүдэлчин амьдралын онцлогийн тухай
 - Нүүдэлчин амьдралын суурин аж төрөх ёсны тухай
5. Эсээний гол санааг илэрхийлэх түлхүүр өгүүлбэрийг олоорой.
- Тэр цагийн хаадын нүүж яваа хүрээ, суурин иргэдийн жуулчин, хэсүүлчний нүдэнд талын энгээр алгуурхан хөдөлж байгаа хот мэтээр төсөөлөгддөг байсан.
 - Нүүдэлт-суурьшлын талаар дэлхийн түүхэнд зураг сэлттэйгээ үлдсэн баримт бол XIII зууны үеийн монгол хаадын олон арван шар хөллөн нүүдэг их гэр тэрэг нь юм.
 - Ямар ч малыг маллагаа, уналга эдэлгээнд сургахдаа тогтмол харилцаа, дадал зуршилтай болгохыг зорьдог.
 - Нүүдэлчин монголчуудын амьдралын дэг журам, хэвшил зуршил, дадал заншил бол нүүдэл дунд бий болгосон суурьшил.
 - Уургад сайн хэвшсэн морь уургын үзүүр толгойнх нь тус газарт очиход л өөрөө зогсон баригддаг.
6. Зохиогчийн ашигласан баримт мэдээллийг шинжилж, зөв харгалзааг олоорой.

Баримтын шинжилгээ		
1	2	3
Баримтаас төрсөн зохиогчийн сэтгэгдэл	Нүүдэлчин амьдралын тухай зохиогчийн өвөрмөц бодол-эргэцүүлэл бүхий баримт	Ажиглалтаас үүдэн гарсан таамаглал

Эсээнээс сонгосон баримт		
а	б	с
Хониных нь хот, үхэр тугал, ингэ ботгах нь зэл ямар ч улиралд хэд хэчнээн ч нүүж, хаа ч буулаа гэсэн анх айл болоод байрлуулсан байр, зүг чигийг нь хэзээ ч өөрчилдөггүй.	Их гэр тэрэгнээс гадна дөрөв, найман үхэр хөллөсөн бэсрэг гэр тэрэгнүүд ч олон байсан байж таарна.	Ерөөс малыг сургахдаа монголчууд гаргууд. Хэвшүүлсэн зуршлыг нь гажуудуулах үед “Мал муу зан сургалаа” хэмээн зэмлэдэг.

A. 1a, 2b, 3c B. 1c, 2a, 3b C. 1a, 2c, 3b D. 1b, 2a, 3c E. 1b, 2c, 3a



7. Нэгэн хэвийн, нэгэн голдиролт амьдралын хэмнэл ямар үр дүнд хүрсэн бэ?
- Бусдаас ялгагдах аж төрөх ёс бий болсон.
 - Эцэг өвгөдийн уламжлалыг сахидаг болсон.
 - Гэрийн гадаах орчноо өөрчилдөггүй болсон.
 - Гэр дотроо нүүж суудаггүй ёс хэвшсэн.
 - Тогтонги хэвшил зуршилтай болсон.
8. Зохиогчийн сайшаасан үнэлэмж илэрсэн үзэл бодол бүхий өгүүлбэрийг олоорой.
- Амгалангаас илүү жаргалан гэж үгүй.
 - Ерөөс малыг сургахдаа монголчууд гаргууд.
 - Чухамхүү үргэлжийн хөдөлгөөн л амгаланг буй болгоно.
 - Энэ зорилгынхоо үүднээс зарим хэрэгслийг өөрчилсөн.
 - Хүн төрөлхтний үлэг оршил нь нүүдэл.
9. Эсээний нэг нь нөгөөдөө багтсан (агуулах → агуулагдах) харьцааг илэрхийлж буй үг хэллэг аль вэ?
- их гэр тэрэг → бэсрэг гэр тэрэг
 - хэвшил зуршил → дадал заншил
 - дэг журам → тогтмол харилцаа
 - үргэлжийн хөдөлгөөн → тайван тогтонги
 - эд агуурс → орон гэр
10. “Гэр дотроо нүүдэггүйтэйгээ нэг адил гэрийн гадаах орчноо ч өөрчилдөггүй.” өгүүлбэрт зохиогчийн ашигласан найруулгын уран маягийг оновчтой тайлбарласан нь аль вэ?
- Гэрийн дотор, гадаахаас давуу болохыг ахиулан тайлбарласан
 - Дотор, гадаах хоёрын эсрэг болохыг сэргүүлэн тайлбарласан
 - Нүүх, өөрчлөх хоёрын төстэй болохыг ижилсүүлэн тайлбарласан
 - Нүүдэггүй, өөрчилдөггүй үйл явцыг бууруулан тайлбарласан
 - Орчны ижил чанарын тэгш эрхтэйг зэрэгцүүлэн тайлбарласан
11. “Энэ зорилгынхоо үүднээс мал маллагааныхаа зарим хэрэгслийг **өөрчилсөн нь** ажиглагддаг.” өгүүлбэрийн “өөрчилсөн нь” гэсэн үгийг оновчтой салаалан хувиргасан нь аль вэ?
- Энэ зорилгынхоо үүднээс мал маллагааныхаа зарим хэрэгслийг сольсон нь ажиглагддаг.
 - Энэ зорилгынхоо үүднээс мал маллагааныхаа зарим хэрэгслийг үлдээсэн нь ажиглагддаг.
 - Энэ зорилгынхоо үүднээс мал маллагааныхаа зарим хэрэгслийг халсан нь ажиглагддаг.
 - Энэ зорилгынхоо үүднээс мал маллагааныхаа зарим хэрэгслийг цуцалсан нь ажиглагддаг.
 - Энэ зорилгынхоо үүднээс мал маллагааныхаа зарим хэрэгслийг больсон нь ажиглагддаг.
12. “**Тайван тогтонги**, зуршил хэвшлийг эрхэмлэдэг үндэстэн бол монголчууд.” өгүүлбэрийн “тайван тогтонги” гэсэн үг аль үгтэй холбогдож, ямар гишүүн болох вэ?
- “үндэстэн” үгтэй холбогдож, тодотгол гишүүн
 - “эрхэмлэдэг” үгтэй холбогдож, шууд бус тусагдахуун гишүүн
 - “зуршил” үгтэй холбогдож, шууд тусагдахуун гишүүн
 - “хэвшлийг” үгтэй холбогдож, тодотгол гишүүн
 - “эрхэмлэдэг” үгтэй холбогдож, шууд тусагдахуун гишүүн
13. Олон гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэрийг олж сонгоорой.
- Өдөр тутмынх нь ажил үйлс нэгэн хэвийн, нэгэн голдиролт бөгөөд чухамхүү энэ хөдөлгөөн хийгээд тогтонги нь бусдаас ялгагдах аж төрөх ёсыг бий болгожээ.
 - Ямар ч малыг маллагаа, уналга эдэлгээнд сургахдаа тогтмол харилцаа, дадал зуршилтай болгохыг зорьдог.
 - Эргэх дөрвөн цагийн турш хөдөлгөөнд оршиж байдаг атлаа хувьсал өөрчлөлтгүй байхыг ямагт эрмэлздэг.
 - Хүрээлэн буй орчных нь уул ус, гүвээ толгод, адуу малын бэлчээр хорь гуч хоногийн давтамжтайгаар өөрчлөн шинэчлэгдэж байдаг.
 - Хэд ч нүүж, хаа ч буусан гэр доторх хийгээд гэрийн гадаах өөрсдийн буй болгосон орчныг тэр чигээр нь ямар ч өөрчлөлтгүйгээр аваад яваад байдаг гэсэн үг юм.
14. “Хөдөлгөөн гэгч өөрөө тайван тогтонгийг **үүддэгт** оршино.” өгүүлбэрийн “үүддэг” гэсэн үгээр зохиогч үйл хөдлөлийн ямар утга илэрхийлэхийг зорьсон бэ?
- удирдан чиглэсэн
 - үүд хаалгыг нээсэн
 - тэнцвэржин тогтсон
 - үүсэж бий болсон
 - устаж үгүй болсон
15. Эсээнд байгаа “өвгөд” гэсэн үгтэй нэг гаралтай үгийг олоорой.
- өвчүү
 - өвөг
 - өвөл
 - өвөөлж
 - өвдөг
16. Үйлээс нэр үг бүтээх -л дагавартай бүлэг үг нь аль вэ?
- хэвшил, уламжил, хэмнэл, дадал
 - амьдрал, зуршил, заншил, бугуйл
 - нүүдэл, зуршил, хэвшил, дадал
 - батал, амьдрал, улирал, байрлал
 - байрлал, хэвшил, дадал, суурьшил



17. Үгийн бүтцийн зүй тогтлыг ажиглаад цэгийн оронд тохирох үгийг олоорой.

маллагаа, хүрээлэн, эдэлгээ, үндэстэн, ...

- A. дүгнэлт B. жаргалан C. давтамж D. захиргаа E. хэсүүлчин

18. Нэрийн хамаатуулах нөхцөлөөр хэлбэржсэн холбоо үгсийг олоорой.

- A. дэлхий дахинаа, зорилгын үүднээс
B. зураг сэлттэйгээ, гадаах орчноо
C. хэдэн үеэрээ, уналга эдэлгээ
D. тогтмол харилцаа, мал маллагаандаа
E. хөдөлж байгаа, дэлхий даяараа

19. Доорх үгсийн бүтээврийн нийлц дэх дүрмийн зөв бодомжийг олоорой.

хэрэгсэл	+	ээс	=	хэрэгслээс	хоймор	+	ын	=	хоймрын
----------	---	-----	---	------------	--------	---	----	---	---------

- A. Гийгүүлэгчээр төгссөн үгэнд урт эгшгээр эхэлсэн залгавар залгахад эцсийн гийгүүлэгчийн өмнөх балархай эгшиг бусад дүрэмд харшлахгүй бол гээгдэнэ.
B. Гийгүүлэгчээр төгссөн үгэнд гийгүүлэгч залгахад үгийн эцсийн гийгүүлэгчийн өмнөх балархай эгшиг гээгдэнэ.
C. И-ээс бусад богино эгшгээр төгссөн үгэнд урт эгшгээр эхэлсэн залгавар залгахад үгийн эцсийн богино эгшиг гээгдэнэ.
D. Гийгүүлэгчээр төгссөн үгэнд урт эгшгээр эхэлсэн залгавар залгахад эцсийн гийгүүлэгчийн өмнөх балархай эгшиг бусад дүрэмд харшлахгүй бол гээгдэхгүй.
E. Дараалсан хоёр гийгүүлэгчийн хоёрдугаар гийгүүлэгч нь хоолойн г, хэлний үзүүрийн н хоёрын нэг байвал түүний өмнө и-ээс бусад балархай эгшиг бичихгүй.

20. “Гийгүүлэгчээр төгссөн үгэнд гийгүүлэгч залгахад үгийн эцсийн гийгүүлэгчийн өмнөх балархай эгшиг гээгдэнэ.” дүрэмд хамаарах үг аль нь вэ?

- A. хэмнэл B. хэвшил C. найман D. уналга E. дөрвөн

21. Зөөлний тэмдэг и болсон үг аль нь вэ?

- A. зорилго B. оршил C. жуулчин D. зарим E. зуршил

Уран зохиол:

- Л.Түдэвийн “Оройгүй сүм” романы хэсгийг уншиж ойлгоод, даалгаврыг гүйцэтгээрэй.

...Хоёр давхар алтадсан оройтой, ногоон паалантай туйпуугаар уран гоё барьсан, жижигхэн дуган дотор төвлөрүүлэн босгосон, давтмал мөнгөн чимэгтэй, шар торгон өнгөлөгтэй суваргын өмнө хэдэн зуун зул ярайж байлаа.

Суваргын эгц өмнөх сэнтий мэт ширээнээ нэг алт, хоёр мөнгө, нэг чулуун цөгцтэй том зул, гуулин цөгцтэй жижиг зулнууд, тэрнээс цааш мөргөлчдийн тавьсан тоо томшгүй олон зул байна. Гэлэн Чоймчиг тус бүр нь таван чох* зоосны үнэтэй жижигхэн зул гурвыг хажуугийн мухлагаас худалдан авч ирээд, нэгийг гэгцэл Санжид өгч, нөгөө хоёрыг өөрөө асааж суваргын өмнө өргөв. -За одоо санаа амарлаа! гэж Чоймчиг гэлэн шавийнхаа чихэнд шивгэнээд гарахаар үүд зүглэв. “Багш ламтан баруун хийдэд Далай лам зургаадугаарын шарилд зул өргөхдөө “За одоо санаа амарлаа” гэж байсан. Энд бас л тэгж хэлэх юм. Санаа нь нэг л юманд зовоод яваа юм уу даа? Юунд зовдог билээ? Төрөл садан ч үгүй, эр ганц хүн шүү дээ. Эсвэл ер нь тэгж хэлдэг заншилтай юм уу?” гэж гэгцэл бодов. Багшийгаа огт барцадгүй хүн гэж тэр итгэдэг юм...

чих* - хятад зоос

22. Зохиолын хэсгээс шашны хам сэдвийг тодорхойлох үг хэллэгийг олж сонгоорой.

- A. алтадсан орой, ногоон паалантай туйпуу, давтмал мөнгөн чимэг
B. шар торгон өнгөлөгтэй суварга, чулуун цөгцтэй том зул, Далай лам
C. нэг алт, хоёр мөнгө, гуулин цөгцтэй жижиг зул, төрөл садан
D. хажуугийн мухлаг, эр ганц хүн, барцадгүй хүн, шарилд зул өргөх
E. гэгцэл Санж, гэлэн Чоймчиг, Далай лам, сэнтий мэт ширээ

23. Зохиолын тодруулсан хэсэгт үндэсний бахархалт сэтгэлгээний ямар утга илэрч байна вэ?

- A. Дархан хүний ур ухаанаа шингээн босгосон бүтээлийг магтах утга
B. Бурхан шашны сүм суваргын үзэмж төрхийг илэрхийлэх утга
C. Сүм дуганын чанар чансаа, өнгө үзэмжийг товойлгон дүрслэх утга
D. Төрөл бүрийн эд зүйлийг ашиглаж байсан тухай тайлбарлах утга
E. Хүний гараар бүтээсэн уран барилгын хийцийг нарийн дүрслэх утга

24. Зохиолын хэсэгт хэтрүүлэн ихэсгэсэн уран дүрслэл аль нь вэ?

- A. огт барцадгүй хүн B. сэнтий мэт ширээ
C. эр ганц хүн D. хэдэн зуун зул
E. паалантай туйпуу



25. Санжийн дотоод ярианаас дүрийн бодлын өсөлтийг оновчтой илэрхийлсэн бичиглэлийг олоорой.

A.	зул	→	чих	→	эр	→	итгэл
B.	хэлснийг санах	→	өөрөөсөө асуух	→	бодох	→	итгэх
C.	санаа амрах	→	дахин хэлэх	→	санаа зовох	→	бодох
D.	асаах	→	өргөх	→	шивгэнэх	→	гарах
E.	багшийн үг	→	нэг юм	→	төрөл садан	→	заншил

26. Чоймчиг гэлэнгийн “За одоо санаа амарлаа!” гэсэн үгээр дотоод орчны ямар өнгө аяс илэрч байна вэ?

- A. Гэлэнгийн үнэнхүү сүсэглэсэн өнгө аяс
B. Шавьдаа бүхнээ даатгахаар шийдсэн өнгө аяс
C. Зорьсон ажилдаа сэтгэл ханасан өнгө аяс
D. Дутуу дулимагтаа сэтгэл зовсон өнгө аяс
E. Сэтгэл шүлүүдаж, яарч догдолсон өнгө аяс

27. Багшийн хэлсэн үг, хийсэн үйлдэл Санжийн дүрд хэрхэн нөлөөлж байна вэ?

- A. Бусдын төлөө санаа зовних сэтгэлтэй болоход нөлөөлсөн.
B. “За одоо санаа амарлаа!” гэх үгийн утгыг ухахад нөлөөлсөн.
C. Далай ламд зул өргөх ёс горимд зөв суралцахад нөлөөлсөн.
D. Багш хүн шавьдаа хэрхэн ханддагийг ойлгоход нөлөөлсөн.
E. Багшийн тухай тунгаан эргэцүүлж, дүгнэлт гаргахад нөлөөлсөн.

28. Цэгийн оронд тохирох үгийг нөхөж уран зохиолын тодорхойлолтыг гүйцээнэ үү.

... дүр гэдэг нь тухайн нийгмийн хүмүүсийн зан төрх, ёс суртахууны шинж байдлыг хадгалсан дүрийг хэлнэ.

- A. болзолт B. бодгаль C. сөрөг D. нийтлэг E. туслах

29. “Монголын нууц товчоо”-д Гурван Мэргэдийн эздийн тухай Жамухын өгүүлсэн:

“Давирах гөлмийн чимээг
Дайны хэнгэргийн дуу гэж
Ташааран дутаагч Тогтоа
Дайд Бүүр Хээрт

Ташаалдан суугаа буй за” хэсгийн хэл найруулга, бичил дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөллийг оновчтой тодорхойлсон нь аль вэ?

- A. Дүрийн байлдаанч чадваргүй, арчаагүй дорой зан төрхийг танихад үзүүлэх нөлөөлөл
B. Дүрийн андуу эндүүтэй, аймхай хулчгар зан төрхийг танихад үзүүлэх нөлөөлөл
C. Дүрийн хөнгөн хийсвэр, буурь суурьгүй зан төрхийг танихад үзүүлэх нөлөөлөл
D. Дүрийн яаруу сандруу, ахар бодолтой зан төрхийг танихад үзүүлэх нөлөөлөл
E. Дүрийн ихэмсэг бардам, ойворгон хөөрүү зан төрхийг танихад үзүүлэх нөлөөлөл

30. “Монголын нууц товчоо”-ы Тэмүүжин, Жамухтай нөхөрлөхдөө хэлсэн:

Ахас дээдсийн үгийг сонсвол,

Аливаа хүн харилцан

Анд нөхөр бололцвол

Амь биедээ арч болж


Аль алиндаа түшиг болж

Амраглан ханилах ёстой” хэсэгт шүлгийн ямар холбоц байна вэ?

- A. тэгш холбоц B. салаавчлах холбоц C. сөөлжүүлэх холбоц
D. хаших холбоц E. зэрэгцэх холбоц

Үндэсний бичиг:

- Эхийг уншиж ойлгоод, асуулт даалгаврыг гүйцэтгээрэй.

[illegible]

31. **ᠰᠡᠭᠡᠵᠡ, дүү нартаа төрийн хэрэг шийдэхийг соёрхсон.**
A. Ээж, дүү нартаа төрийн хэрэг шийдэхийг соёрхсон.
B. Олон гавьяатанд алдар цол, хишиг соёрхсон.
C. Боорч, Мухулайд есөн удаа ял хэлэлцэхгүйг соёрхсон.
D. Дүү нартаа нөхдийнхөө үгийг сонсохыг соёрхсон.
E. Эсгий туургатныг энх шударга болгохыг соёрхсон.

32. **ᠬᠠᠶ᠋ᠢᠨ ᠬᠤᠨᠢЙ суудалд морилох**
A. Хаан хүний суудалд морилох
B. Хааны сууж байсан сууринд суух
C. Хааны хойчийг залгамжлан суух
D. Хаан сэнтийд тухлан суух
E. Хааны эрх мэдлийг хүчээр авах

33. **ᠬᠠᠶ᠋ᠢᠨ ᠬᠣᠶᠴᠢЙГ Залгамжлан суух**
A. Хаан хүний суудалд морилох
B. Хааны сууж байсан сууринд суух
C. Хааны хойчийг залгамжлан суух
D. Хаан сэнтийд тухлан суух
E. Хааны эрх мэдлийг хүчээр авах

34. **ᠬᠠᠶ᠋ᠢᠨ ᠫᠤᠯᠠᠮᠪᠠᠳᠤᠷ᠎ᠠᠭᠤᠢ**
A. Хаан хүний суудалд морилох
B. Хааны сууж байсан сууринд суух
C. Хааны хойчийг залгамжлан суух
D. Хаан сэнтийд тухлан суух
E. Хааны эрх мэдлийг хүчээр авах

35. **ᠬᠠᠶ᠋ᠢᠨ ᠫᠤᠯᠠᠮᠪᠠᠳᠤᠷ᠎ᠠᠭᠤᠢ**
A. Хаан хүний суудалд морилох
B. Хааны сууж байсан сууринд суух
C. Хааны хойчийг залгамжлан суух
D. Хаан сэнтийд тухлан суух
E. Хааны эрх мэдлийг хүчээр авах

36. **ᠬᠠᠶ᠋ᠢᠨ ᠫᠤᠯᠠᠮᠪᠠᠳᠤᠷ᠎ᠠᠭᠤᠢ**
A. Хаан хүний суудалд морилох
B. Хааны сууж байсан сууринд суух
C. Хааны хойчийг залгамжлан суух
D. Хаан сэнтийд тухлан суух
E. Хааны эрх мэдлийг хүчээр авах



- | | | | | | | | |
|-----|---|--|--|--|--|--|--------------------|
| 37. | <p>37. Өглөг, хувь
үндэстэн, улс
зөвшөөрөл, итгэл</p> | <p>1. Өглөг, хувь
үндэстэн, улс
зөвшөөрөл, итгэл</p> | <p>2. Өглөг, хувь
үндэстэн, улс
зөвшөөрөл, итгэл</p> | <p>3. Өглөг, хувь
үндэстэн, улс
зөвшөөрөл, итгэл</p> | <p>A. 1b,2c,3a
D. 1c,2a,3b</p> | <p>B. 1c,2b,3a
E. 1b,2a,3c</p> | <p>C. 1a,2b,3c</p> |
| 38. | <p>38. Өглөг, хувь
үндэстэн, улс
зөвшөөрөл, итгэл</p> | <p>A. Өглөг, хувь
үндэстэн, улс
зөвшөөрөл, итгэл</p> | <p>B. Өглөг, хувь
үндэстэн, улс
зөвшөөрөл, итгэл</p> | <p>C. Өглөг, хувь
үндэстэн, улс
зөвшөөрөл, итгэл</p> | <p>D. Өглөг, хувь
үндэстэн, улс
зөвшөөрөл, итгэл</p> | <p>E. Өглөг, хувь
үндэстэн, улс
зөвшөөрөл, итгэл</p> | |
| 39. | <p>39. Өглөг, хувь
үндэстэн, улс
зөвшөөрөл, итгэл</p> | <p>a. төр – улсын засаг
дөр – эв дүй, арга
дүр – уран зохиолын дүр</p> | <p>1. Өглөг, хувь
үндэстэн, улс
зөвшөөрөл, итгэл</p> | <p>2. Өглөг, хувь
үндэстэн, улс
зөвшөөрөл, итгэл</p> | <p>A. a2,b1,c1
D. a2,b2,c1</p> | <p>B. a1,b1,c2
E. a1, b2,c1</p> | <p>C. a2,b1,c2</p> |
| 40. | <p>40. Өглөг, хувь
үндэстэн, улс
зөвшөөрөл, итгэл</p> | <p>A. Өглөг, хувь
үндэстэн, улс
зөвшөөрөл, итгэл</p> | <p>B. Өглөг, хувь
үндэстэн, улс
зөвшөөрөл, итгэл</p> | <p>C. Өглөг, хувь
үндэстэн, улс
зөвшөөрөл, итгэл</p> | <p>D. Өглөг, хувь
үндэстэн, улс
зөвшөөрөл, итгэл</p> | <p>E. Өглөг, хувь
үндэстэн, улс
зөвшөөрөл, итгэл</p> | |



Хоёрдугаар хэсэг. ХАРГАЛЗУУЛАХ ДААЛГАВАР

Санамж:

- Энэ хэсэг нь 4 даалгавар, нийт 20 оноотой.
- Сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож, тохирох хариуг будаарай.
- Зөв харгалзуулсан хариулт бүр 1 оноотой.

2.1. Хэлц өгүүлбэрийн гэг-, хэмээ- холбох үгийг илрэх утгатай нь харгалзуулаарай. (a, b, c, d, e мөр бүрд нэг хариулт тааруулаарай. 1, 2, 3, 4 дүгээрт байгаа нэр томьёо давхцаж болно.)

Хэлц өгүүлбэр		Холбох үг	Илрэх утга
• Хэлсэн үг нь цэцэн гэж аргагүй • Явсан мөр нь шулуун гэж аргагүй • Харъя гэвэл нүд муу • Хазъя гэвэл шүдгүй • Хамар гэвэл харанхуй нүх.	• Татах гээд түлхэгдэх • Чичлэх гээд алдах. • Хилэгнэх гэгч урины нэр • Харилхана гэгч атааны нэр. • Өгнө гэхэд өрвөс хийнэ • Авна гэхэд арвас хийнэ.	a. гэж b. гэвэл c. гээд d. гэгч e. гэхэд	1. болзлын утга 2. тодосгогчийн утга 3. шалтгааны утга 4. зорилгын утга

2.2. Ятган итгүүлж бичихэд ашиглах дүрслэлийн жишээг нэр томьёотой нь зөв харгалзуулаарай. (a, b, c, d, e мөр бүрд нэг хариулт тааруулаарай. 1, 2 дугаарт байгаа нэр томьёо давхцаж болно.)

- | | |
|-----------------|----------------------|
| a. дулаан хавар | |
| b. хатан зориг | 1. Ерийн тодотгол |
| c. хөх хомоол | 2. Зүйрлэлт чимэг үг |
| d. алд бие | |
| e. мөнгөн сар | |

2.3. Ч.Лодойдамбын “Тунгалаг Тамир” романы тодруулсан хэсгийг уран дүрслэлтэй нь тохируулаарай. (a, b, c, d, e мөр бүрд нэг хариулт тааруулаарай. 1, 2, 3, 4 дүгээрт байгаа нэр томьёо давхцаж болно.)

a. Гайхамшигт гэгээний ид шидэд биширсэн Долгор тэр мундаг чулууны хойгуур гарахдаа гурван халуун амиа даатган хэдэн удаа сунаж мөргөжээ. b. Энэ майханд орсон зовлон надад хамаагүй гэсэн юм шиг Тамирын гол жигдхэн шуугьж, дорно зүгээс улам тодорч байгаа үүрийн гэгээ нойрссон ертөнцөд шинэ өдөр мэндэлснийг баяртай тунхаглана. c. “ Долоо хоногийн өлийг дуулж байгаад давдаг хүн, далан өртөө газрыг дөрөөн дээрээ туулдаг эр ” гэх зэргээр Төмөрийг шагшин магтжээ. d. Эрдэнэ майхны үүдэнд дуугүй зогсож байснаа аргамж, чөдрөө майхны хаяа руу шидэж “ хулгай аваад явчихжээ ” гэж хэлэв. e. — Аав аа, та тэр чулууг орхимжоороо үүрээд явж чадах уу? — Аав нь төрийн хар хүн болохоор орхимж байхгүй.	1. ихэсгэл 2. хүншүүлэл 3. тойруулал 4. төлөөлөл
---	---

2.4. Холбоо үгийг уншаад бичлэг ижил, утга өөр бүтээврийг нэр томьёотой нь харгалзуулаарай. (a, b, c, d, e мөр бүрд нэг хариулт тааруулаарай. 1, 2, 3, 4 дүгээрт байгаа нэр томьёо давхцаж болно.)

- | | | | | | |
|----------|----------|----------|----------|----------|--|
| A. | B. | C. | D. | E. | |
| ᠠᠭᠠᠨᠠᠭᠤᠨ | ᠠᠭᠠᠨᠠᠭᠤᠨ | ᠠᠭᠠᠨᠠᠭᠤᠨ | ᠠᠭᠠᠨᠠᠭᠤᠨ | ᠠᠭᠠᠨᠠᠭᠤᠨ | 1. Үйлээс нэр үг бүтээх -гаа ⁴ дагавар |
| | | | | | 2. Тодотгон холбох -аа ⁴ нөхцөл |
| | | | | | 3. Үйлээс нэр үг бүтээх -аа ⁴ дагавар |
| | | | | | 4. Бусдаар үйлдүүлэх хэвийн -га ⁴ дагавар |

